



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/163

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "д", 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28.3, 42.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.3-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагчдыг эрүүл мэнд болон нийгмийн даатгалд хамруулах нэрс, зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 39 288 000 /гучин есөн сая хоёр зуун наян найман мянган/ төгрөгийг хөрөнгө оруулалтын зардлын жагсаалтын "хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэрээр асарч байгаа ажил хөдөлмөр эрхэлдэггүй асран хамгаалагчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах" зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Дээрхи ажлыг 4 дүгээр сард багтаан зохион байгуулж, ажлын гүйцэтгэлийн тайланг ирүүлэхийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс /н.Анар/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ